

Спортын үйл ажиллагааны төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 13.1.2, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, байгууллагын 2018 оны Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 39 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтнуудын хөдөлгөөний дутагдал, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор спортын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Спортын үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг Газрын даргад танилцуулж ажиллахыг Эрүүл мэнд, биеийн тамирын комисс /Б.Хосбаяр/-т үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах зардлыг бусдаар гүйцэтгүүлэх ажлын төсвөөс бодож олгохыг Нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ч.ЭЛБЭГСЭЙХАН

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк”  
ОНӨТҮГ-ын даргын ... оны ... сарын ... -ны өдрийн  
... дугаар тушаалын хавсралт

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
2018 ОНЫ СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 3 дугаар сар 19

Багануур дүүрэг

**Зорилго:** Ажилтан нарын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл мэнд болон бие бялдрын өв тэгш байдлыг хангах, хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг төлөвшүүлэх

**Зорилт:** Спортын зөв дөртэй болох, спортын авъяасыг нээн илрүүлэх

**Хүрэх үр дүн:** Байгууллагын спортын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдэд паркийг сурталчлах, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох, бусад албан газруудтай танилцах, цаашлаад бусад Парктай нөхөрсөг тэмцээн зохион байгуулах зэрэг үр дүнд хүрнэ.

	Арга хэмжээ	Хугацаа, хаана	Зохион байгуулагч	Зардал	Төсөв
1	Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэх	2018 оны 3 дугаар сараас өдөр бүр	Спорт, эрүүл мэндийн комисс	-	-
2	Спорт зааланд тогтмол хичээллэх	7 хоногт 1 удаа, тус бүр 2 цагаар /3 сарын хугацаанд/	БҮТП өөр байгууллагатай хамтарна.	30'000х6 Заалны цаг	180'000
3	Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан ширээний теннисний аварга шалгаруулах	3р сар/МСХ ТӨК-ийн байр, теннисний өрөөнд	Байгууллагын эрчүүд	30'000х2 шагнал	50'000
4	Байгууллагын биллиардын аварга тодруулах /Эр, Эм/	10 дугаар сард	БҮТП-ийн спорт, эрүүл мэндийн комисс	5000х4 цаг 2х20'000 шагнал	60'000
5	Байгууллагын шатар, Даамны аварга тодруулах	5 дугаар сард Байгууллагын байранд	БҮТП-ийн спорт, эрүүл мэндийн комисс	30.000х2 шагнал	60'000

6	Хүүхдийн баярын арга хэмжээ зохион байгуулах	6 дугаар сард байгууллагын байранд	БҮТП-ийн хамт олон	300'000 бэлэг	300'000
7	Байгууллагын тоглолтын хувцастай болох	3 дугаар сард	БҮТП-ийн захиргаа	6x20'000	120'000
	Нийт				770'000 төгрөг

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Б.ХОСБАЯР  
 Бүртгэл мэдээлэл, программ хангамж  
 хариуцсан мэргэжилтэн

